



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр, Б корпус,
Утас/Факс: (976-51) 26 00 62,
И-мэйл: info@spa.gov.mn, Вэбсайт: www.spa.gov.mn

2020.06.23 № А-1/1289
танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан XII.1.1.285 “Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсэнтэй холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
Техникийн нөхцөл өгөгдөөгүй байгаа нь гадна инженерийн шугам сүлжээний ажил нь дахин тендер зарлахаар тусгагдаж байгаа эсэх	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн XII.1.1.285 “Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний гадна шугам сүлжээний ажлын техникийн нөхцөл өгөгдөөгүй тул гадна цэвэр усыг гүний худгийн барилгатай, 100 метрийн гүнээс ус гаргахаар тооцох, бохир усыг бие даасан байдлаар шийдвэрлэх бөгөөд 30м3-ээс багагүй, соруулдаг байдлаар хийх, гадна цахилгааны нөөц эх үүсвэрийг 120кВт-аас багагүй хүчин чадалтай дизел генератор байхаар тооцох ба гадна цахилгааны ажлын техникийн нөхцөл олгогдсоны дараа шийдвэрлэнэ.
Нэг маягийн зургаар орно гэдэг нь өөрийн гэсэн нэг маягийн зурагтай холболт хийдэг зураг төслийн компани сонгох боломжтой эсэх талаар тодруулга хүсч байна. / зураг төслийн компанийг зааж өгч байгаа нь өрсөлдөөнийг хязгаарлах талтай байна./	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг нэг маягийн зургаар барихаар төлөвлөн ажиллаж байна. Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд баригдах энэхүү цэцэрлэгийн барилгыг барихад “Татах хүч” ХХК-ийн боловсруулсан нэг маягийн зураг илүү тохирно гэж үзсэн болно. Тендерт оролцогч нь зураг төсөв гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй, хуулийн этгээдтэй хамтран оролцно.
Тендер зарласан хугацаанд нэмэлт тодруулга гарсан тул тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд дараах өөрчлөлтүүдийг оруулж байна.	
ТӨӨЗ 19.1-д Тендерийн баталагааны хүчинтэй байх хугацаа	2020 оны 8 дугаар сарын 30-ны өдрийг дуустал
ТӨӨЗ 23.1-д Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:	2020 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 14.00 цагт
ТӨӨЗ 26.1-д Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:	2020 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 14.10 цагт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас ирүүлсэн тодруулгын хуулбарыг хавсаргав.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.УЛАМ-ӨРНӨХ

ТХААГ-2020-А4



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589
E-mail: info@mecss.gov.mn, http:www.mecss.gov.mn

2020.06.22 № 2/4179
танай _____-ны № _____-г

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Танай газраас ирүүлсэн 2020 оны А-1/1223 тоот тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн XII.1.1.285-д батлагдсан Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний гадна инженерийн шугам сүлжээний ажлын техникийн нөхцөл өгөгдөөгүй тул гадна цэвэр усыг гүний худгийн барилгатай, 100 метрийн гүнээс ус гаргахаар тооцох, бохир усыг бие даасан байдлаар шийдвэрлэх бөгөөд 30 мЗ-с багагүй, соруулдаг байдлаар хийх, гадна цахилгааны нөөц эх үүсвэрийг 120 кВт-с багагүй хүчин чадалтай дизел генератор байхаар тооцох ба гадна цахилгааны ажлыг техникийн нөхцөл олгогдсоны дараа шийдвэрлэнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг батлагдсан нэг маягийн зургаар барихаар төлөвлөн ажиллаж байна. Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд баригдах энэхүү цэцэрлэгийн барилгыг барихад Татах хүч ХХК-ийн боловсруулсан нэг маягийн зураг илүү тохирно гэж үзсэн болно.

Тендерт оролцогч нь зураг төсөв гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй, хуулийн этгээдтэй хамтран оролцож болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  Л.ЦЭДЭВСҮРЭН

D:\Албан тоот\2020

1420114862